

## ШИЛДЭГ ИЛТГЭЛ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНД ОРОЛЦОНО УУ



Геодези, зураг зүйн салбарын 90, Төрийн захиргааны байгууллага байгуулагдсаны 50 жилийн ойд зориулан зохион байгуулж буй шилдэг илтгэл шалгаруулах уралдаанд их, дээд сургуулийн Геодези, зураг зүйн чиглэлээр суралцаж буй геодезийн бакалаврын ангийн оюутан, салбарын мэргэжилтэн, инженер техникийн ажилтнууд, судалгаа, шинжилгээний ажилтан, багш, докторант, магистрант та бүхнийг оролцохыг урьж байна.

### **“ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ – 90 ЖИЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсад Геодези, зураг зүйн салбар үүсч хөгжсөний 90 жил, эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан их, дээд сургуулиудын геодезийн чиглэлээр суралцаж буй бакалаврын оюутнууд, салбарын мэргэжилтэн, инженер техникийн ажилтнууд, судлаачид /цаашид “оролцогч” гэх/-ын дунд шилдэг илтгэл шалгаруулах, эрдэм шинжилгээний хурлын хүрээнд шилдэг илтгэл шалгаруулахад энэхүү удирдамжийг мөрдөнө.

#### **Хоёр. Ангилал**

2.1. Шилдэг илтгэлийг 2 ангиллаар шалгаруулна. Үүнд:

2.1.1. Оюутны илтгэл /Их, дээд сургуулийн Геодези, зураг зүйн чиглэлээр суралцаж буй геодезийн бакалаврын ангийн оюутан/

2.1.2. Судлаачийн илтгэл /Геодези, зураг зүйн мэргэжилтэн, инженер техникийн ажилтнууд, судалгаа, шинжилгээний ажилтан, багш, докторант, магистрант/

#### **Гурав. Уралдааны болзол**

3.1. Оролцогчид дараах сэдвийн хүрээнд илтгэл бичиж ирүүлнэ.

3.1.1. Шинжлэх ухаан болон үйлдвэрлэлийг холбох;

3.1.2. Геодези, зураг зүйн судалгаа шинжилгээний ажлын цар хүрээг тэлэх;

3.1.3. Геодези, зураг зүйн судлаачдын бүтээл,

3.1.4. Геодези, зураг зүйн салбарт тулгамдаж буй асуудал, түүний шийдвэрлэх.

3.2. Илтгэлд тавигдах шаардлага:

3.2.1. Өгөгдсөн сэдвийн хүрээнд одоогийн байгаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тандан судалсан байх;

3.2.2. Олон улсад хэрэглэгдэж буй дэвшилтэт техник, технологийг тусгах /техникийн тодорхойлолт, давуу тал, сул тал, техникийн шийдэл, гарах үр дүн/;

3.2.3. Геодезийн салбарын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд оновчтой хувилбарыг дэвшүүлсэн байх;

3.2.4. Монгол Улсад хэрэгжүүлэх боломж, шийдлийг тодорхойлсон байх;

3.2.5. Дэвшүүлж буй саналын нийгэм, эдийн засаг, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг тооцсон байх;

3.2.6. Ашигласан ном зохиол, бүтээл, судалгааны эх сурвалжийг тодорхой дурдсан байх;

3.3. Илтгэл нь 4-өөс доошгүй хуудастай байх, А4 (210\*297мм) ба компьютерийн Word програмыг ашиглан Times New Roman фонтын 12 хэмжээгээр, мөр хооронд 1 (single)-ийн зайтайгаар бичигдсэн байна.

### **Дөрөв. Бүртгэл**

4.1. Илтгэлийг цаасан дугтуйнд хийж битүүмжлэн овог нэр, хаяг, холбоо барих утсыг тодорхой бичиж 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 17.00 цаг хүртэл Засгийн газрын XII байр 125 тоотод ирүүлэх эсвэл [undarmaa.d@gazar.gov.mn](mailto:undarmaa.d@gazar.gov.mn) э-мэйл хаягаар ирүүлнэ.

4.2. Товлосон цагаас хугацаа хоцорсон илтгэлийг хүлээж авахгүй.

### **Тав. Шалгаруулалт**

5.1. Шалгаруулалтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн Газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг шалгаруулна. Шалгаруулалт 2 үе шаттайгаар явагдана.

5.1.1. Нэгдүгээр үе шатанд оролцогчийн ирүүлсэн илтгэлийг ажлын хэсгийн гишүүд нэг бүрчлэн танилцаж, энэхүү удирдамжийн 3.2-т заасан шаардлагуудын дагуу дүгнэнэ. Ажлын хэсгийн гишүүн бүр 3.2.1-3.2.5 дахь үзүүлэлтүүдийн дагуу 0-10 оноо, 3.2.6 дахь үзүүлэлтэд 0-5 оноогоор дүгнэнэ. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн онооны дунджаар хамгийн өндөр оноотой 10 оролцогчийн илтгэлийг 2 дугаар шатанд шалгаруулна.

5.1.2. Хоёрдугаар шатанд шалгарсан 10 оролцогч илтгэлээ PowerPoint програм дээр танилцуулна. Нэг оролцогчийн илтгэх хугацаа 10 минут байна.

**5.2. Танилцуулга Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хурлын танхим /205 тоот/-д 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цагт зохион байгуулагдана.**

5.3. Ажлын хэсгийн гишүүд оролцогчдын илтгэх ур чадвар, илтгэлийн утга санаа хөндсөн асуудлыг оновчтой илэрхийлж буй байдлыг харгалзан 10-20 оноогоор дүгнэнэ.

5.4. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн онооны дунджаар хоёрдугаар шатны дүнг гаргана.

5.5. Оролцогчдыг нэг, хоёрдугаар үе шатанд авсан онооны нийлбэрээр байр эзлүүлэн 1-3 дугаар байрыг тус бүр шалгаруулна.

5.6. Байр эзэлсэн оролцогчдыг батламж, мөнгөн шагналаар урамшуулна.

5.7. Шалгарсан илтгэлүүдийг ажлын хэсгийн ахлагч уралдааны шалгаруулалтын дүн, илтгэлд дэвшүүлсэн шинэлэг санаа, шийдэл, цаашид авах арга хэмжээний саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын удирдлагад танилцуулна.

### **Зохион байгуулагч**

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо.

### **Холбоо барих**

Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Засгийн газрын XII байр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 125 тоот өрөө

**Утас:** 262461, 96010953, 88056133

**Цахим хаяг:** [www.gazar.gov.mn](http://www.gazar.gov.mn)